



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ГСА-2022/64/СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Говьсүмбэр аймаг

2022 он

Дарга тэргүүлэх аудитор:

Утас: 7054-3156 Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn

Аудитын менежер:

Утас: 7054-3179 Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn

Ахлах аудитор:

Утас: 7054-3179 Цахим хаяг: Darkhanbatb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	14
3. Аудитын тайлан.....	15
3.1 Ерөнхий зүйл.....	15
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	16
3.4 Материаллаг байдал	16
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	16
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	18
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	19
3.8 Аудитын гол асуудал	19
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	20
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
3.11 дараагийн аудитаар анхаарах асуудал илрээгүй.	20
4. Аудитын илрүүлэлт	20
4.1 Залруулсан алдаа	20
4.2 Албан шаардлага	20
4.4 Зөвлөмж.....	21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ГСА	Говьсүмбэр аймаг
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: govisumber@audit.gov.mn

АЙМГИЙН “МАЛ ЭМНЭЛГИЙН
ГАЗАР”-ЫН ТӨСВИЙН ЗАХИРАГЧ
Ч.ОТГОНСҮРЭН ТАНАА

2022.02.24 № 02

танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн “Мал эмнэлгийн газар”-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн “Мал эмнэлгийн газар”-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

4208020007

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	236,798,418.8	219,605,206.9
33	АВЛАГА	1,684.0	0.0
33500	Бусад авлага	1,684.0	0.0
33520	Хувь хүмүүсээс авах авлага	1,684.0	0.0
34	УРЬДЧИЛГАА	0.0	7,200,000.0
34600	Урьдчилж гарсан зардал	0.0	7,200,000.0
35	БАРАА МАТЕРИАЛ	236,796,734.8	212,405,206.9
35100	Түүхий эд материал	206,580,512.3	187,014,586.5
35130	Эм боох материал	206,580,512.3	187,014,586.5
35400	Хангамжийн материал	30,216,222.4	25,390,620.4
35410	Бичиг хэргийн материал	1,792,565.0	1,413,640.0
35420	Аж ахуйн материал	7,590,583.0	5,997,300.0
35440	Түлш, шатах тослох материал	1,896,750.0	259,350.0
35450	Барилгын засварын материал	937,000.0	922,000.0
35470	Бусад хангамжийн материал	17,999,324.4	16,798,330.4
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	179,364,000.4	205,971,230.2
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	179,364,000.4	205,971,230.2
39100	Газар	0.0	0.0
39200	Биет хөрөнгө	177,622,889.1	137,840,118.8
39201	Барилга, байгууламж, орон сууц	14,350,400.0	14,350,400.0
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,197,311.3	-1,914,831.3
39203	Авто-тээврийн хэрэгсэл	167,308,200.7	167,308,200.7
39204	Хуримтлагдсан элэгдэл	-83,490,994.3	-102,974,602.8
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	73,560,083.8	77,809,083.8
39206	Хуримтлагдсан элэгдэл	-5,544,156.2	-25,376,798.4
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,931,500.0	18,931,500.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	-6,294,833.4	-10,292,833.1
39300	Биет бус хөрөнгө	1,741,111.3	68,131,111.4
39301	Програм хангамж	2,430,000.0	2,430,000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	-688,888.7	-1,498,888.6
39303	Бусад биет бус хөрөнгө	0.0	67,200,000.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	416,162,419.1	425,576,437.1
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	93,077.0	0.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	93,077.0	0.0
41300	Өглөг	93,077.0	0.0
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	93,077.0	0.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	416,069,342.1	425,576,437.1
51	Засгийн газрын хувь оролцоо	416,069,342.1	425,576,437.1
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	0.0	67,200,000.0
51200	Хуримтлагдсан үр дүн	413,839,652.3	356,146,747.3
51210	Өмнөх үеийн үр дүн	293,712,250.1	412,364,752.3

Говьсүмбэр аймгийн “Мал эмнэлгийн газар”-ын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

51220	Тайлант үеийн үр дүн	120,127,402.2	-56,218,005.1
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,229,689.8	2,229,689.8
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	416,162,419.1	425,576,437.1

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,092,072,239.9	664,599,679.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	645,459,799.9	291,369,539.5
120	Нийтлэг татварын бус орлого	645,459,799.9	291,369,539.5
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	398,480.0	913,140.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	398,480.0	913,140.0
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	107,292,841.8	0.0
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	537,768,478.2	290,456,399.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	446,612,440.0	373,230,140.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	247,572,600.0	284,339,000.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	247,572,600.0	284,339,000.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	199,039,840.0	88,891,140.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	199,039,840.0	88,891,140.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	971,944,837.7	720,817,684.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	971,944,837.7	720,817,684.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	969,103,222.7	693,998,317.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	36,564,800.0	181,783,611.0
210101	Үндсэн цалин	31,402,600.0	162,276,813.0
210102	Нэмэгдэл	3,873,700.0	8,263,937.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,288,500.0	3,140,675.0
210104	Урамшуулал	0.0	8,102,186.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,043,811.0	25,057,825.4
210201	Тэтгэврийн даатгал	3,581,311.0	17,966,682.4
210202	Тэтгэмжийн даатгал	365,600.0	1,795,194.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	292,500.0	1,436,074.0
210204	Ажилгүйдлийн даатгал	73,100.0	352,166.0
210205	Эрүүл мэндийн даатгал	731,300.0	3,507,709.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,565,257.2	8,788,647.0
210301	Гэрэл, цахилгаан	647,138.2	651,500.0
210302	Түлш, халаалт	3,715,279.0	4,477,747.0
210303	Цэвэр, бохир ус	202,840.0	259,200.0
210304	Байрны түрээс	0.0	3,400,200.0
2104	Хангамж, бараа материалын зардал	17,297,820.0	15,647,474.2
210401	Бичиг хэрэг	3,398,875.0	2,709,315.0
210402	Тээвэр, шатахуун	5,062,060.0	6,790,100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,495,170.0	1,238,808.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	153,000.0	106,400.0
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	6,907,561.0	3,207,603.0

Говьсүмбэр аймгийн “Мал эмнэлгийн газар”-ын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210408	Бараа материал акталсны зардал	281,154.0	1,595,248.2
2105	Нормативт зардал	516,073,752.4	307,963,077.1
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	516,073,752.4	307,963,077.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.0	644,480.0
210604	Урсгал засвар	0.0	644,480.0
2107	Томилолт, зочны зардал	2,343,500.0	4,006,500.0
210702	Дотоод албан томилолт	2,343,500.0	4,006,500.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	359,304,822.8	103,692,938.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	358,204,552.8	99,233,793.2
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	120,000.0	0.0
210803	Даатгалын үйлчилгээ	339,120.0	375,525.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	58,150.0	197,320.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.0	154,000.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	550,000.0	3,600,000.0
210807	Газрын төлбөр	0.0	132,300.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,909,459.3	46,413,764.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,785,100.0	1,571,994.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	26,124,359.3	44,841,770.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,841,615.0	26,819,367.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,750,500.0	15,560,000.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.0	14,690,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,750,500.0	870,000.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,091,115.0	11,259,367.4
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,090,875.0	10,882,727.4
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	240.0	376,640.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	120,127,402.2	-56,218,005.1
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	120,127,402.2	-56,218,005.1

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	2,229,689.8	293,645,769.1	295,875,458.9
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0.0	66,481.0	66,481.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	2,229,689.8	293,712,250.1	295,941,939.9
4	Тайлант үеийн үр дүн	0	0.0	120,127,402.2	120,127,402.2
5	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	2,229,689.8	413,839,652.3	416,069,342.1
6	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0	2,229,689.8	413,839,652.3	416,069,342.1
7	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0.0	-1,474,900.0	-1,474,900.0
8	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	2,229,689.8	412,364,752.3	414,594,442.1
9	Өмчид гарсан өөрчилөлт	67,200,000.0	0.0	0.0	67,200,000.0
10	Тайлант үеийн үр дүн	0	0.0	-56,218,005.1	-56,218,005.1
11	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	67,200,000.0	2,229,689.8	356,146,747.3	425,576,437.1

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	447,135,820.0	374,144,964.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	523,380.0	914,824.0
120	Нийтлэг татварын бус орлого	523,380.0	914,824.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	523,380.0	914,824.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	523,380.0	914,824.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	446,612,440.0	373,230,140.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	247,572,600.0	284,339,000.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	247,572,600.0	284,339,000.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	199,039,840.0	88,891,140.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	199,039,840.0	88,891,140.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	436,531,220.0	369,895,964.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	436,531,220.0	369,895,964.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	433,689,605.0	342,626,596.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	36,564,800.0	183,710,448.9
210101	Үндсэн цалин	31,402,600.0	162,906,566.9
210102	Нэмэгдэл	3,873,700.0	9,561,021.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,288,500.0	3,140,675.0
210104	Урамшуулал	0.0	8,102,186.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,936,200.0	23,224,064.5
210201	Тэтгэврийн даатгал	3,473,700.0	16,132,921.5
210202	Тэтгэмжийн даатгал	365,600.0	1,795,194.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	292,500.0	1,436,074.0
210204	Ажилгүйдлийн даатгал	73,100.0	352,166.0
210205	Эрүүл мэндийн даатгал	731,300.0	3,507,709.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,565,257.2	8,788,647.0
210301	Гэрэл, цахилгаан	647,138.2	651,500.0
210302	Түлш, халаалт	3,715,279.0	4,477,747.0
210303	Цэвэр, бохир ус	202,840.0	259,200.0
210304	Байрны түрээс	0.0	3,400,200.0
2104	Хангамж, бараа материалын зардал	9,808,600.0	9,745,398.0
210401	Бичиг хэрэг	2,075,600.0	1,890,390.0
210402	Тээвэр, шатахуун	5,309,400.0	6,022,600.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,710,000.0	1,318,908.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	181,900.0	66,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	531,700.0	447,500.0
2105	Нормативт зардал	4,495,700.0	788,600.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,495,700.0	788,600.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,520,500.0	1,309,700.0

Говьсүмбэр аймгийн “Мал эмнэлгийн газар”-ын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210601	Багаж, техник, хэрэгсэл	130,000.0	0.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,900,000.0	0.0
210604	Урсгал засвар	6,490,500.0	1,309,700.0
2107	Томилолт, зочны зардал	2,343,500.0	4,006,500.0
210702	Дотоод албан томилолт	2,343,500.0	4,006,500.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	359,583,747.8	111,023,238.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	358,483,477.8	99,411,993.2
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	120,000.0	0.0
210803	Даатгалын үйлчилгээ	339,120.0	375,525.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	58,150.0	197,320.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.0	106,100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	550,000.0	10,800,000.0
210807	Газрын төлбөр	0.0	132,300.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,871,300.0	30,000.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,871,300.0	30,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,841,615.0	27,269,367.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,750,500.0	16,010,000.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.0	14,690,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,750,500.0	1,320,000.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,091,115.0	11,259,367.4
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,090,875.0	10,882,727.4
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	240.0	376,640.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	10,604,600.0	4,249,000.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	10,604,600.0	4,249,000.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,604,600.0	4,249,000.0
2200	Дотоод эх үүсвэрээр	10,604,600.0	4,249,000.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	10,604,600.0	4,249,000.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-10,604,600.0	-4,249,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.0	0.0
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	285,839,000.0	274,371,096.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	285,839,000.0	274,371,096.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	269,829,000.0	258,361,096.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	191,807,700.0	183,710,448.9
210101	Үндсэн цалин	166,641,500.0	162,906,566.9
210102	Нэмэгдэл	11,473,700.0	9,561,021.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,192,500.0	3,140,675.0
210104	Урамшуулал	9,500,000.0	8,102,186.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,894,100.0	23,224,064.5
210201	Тэтгэврийн даатгал	18,221,700.0	16,132,921.5
210202	Тэтгэмжийн даатгал	1,918,100.0	1,795,194.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,534,500.0	1,436,074.0
210204	Ажилгүйдлийн даатгал	383,600.0	352,166.0
210205	Эрүүл мэндийн даатгал	3,836,200.0	3,507,709.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,443,900.0	8,788,647.0
210301	Гэрэл, цахилгаан	651,500.0	651,500.0
210302	Түлш, халаалт	5,133,000.0	4,477,747.0
210303	Цэвэр, бохир ус	259,200.0	259,200.0
210304	Байрны түрээс	3,400,200.0	3,400,200.0
2104	Хангамж, бараа материалын зардал	7,454,100.0	7,452,398.0
210401	Бичиг хэрэг	1,890,400.0	1,890,390.0
210402	Тээвэр, шатахуун	3,730,400.0	3,729,600.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,319,800.0	1,318,908.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	66,000.0	66,000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	447,500.0	447,500.0
2105	Нормативт зардал	788,600.0	788,600.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	788,600.0	788,600.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,809,700.0	3,809,700.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,500,000.0	2,500,000.0
210604	Урсгал засвар	1,309,700.0	1,309,700.0
2107	Томилолт, зочны зардал	700,000.0	694,000.0
210702	Дотоод албан томилолт	700,000.0	694,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,930,900.0	29,893,238.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,318,800.0	18,281,993.2
210803	Даатгалын үйлчилгээ	376,300.0	375,525.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	197,400.0	197,320.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	106,100.0	106,100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,800,000.0	10,800,000.0
210807	Газрын төлбөр	132,300.0	132,300.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,010,000.0	16,010,000.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,010,000.0	16,010,000.0

Говьсүмбэр аймгийн “Мал эмнэлгийн газар”-ын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14,690,000.0	14,690,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,320,000.0	1,320,000.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	285,839,000.0	274,371,096.6
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	284,339,000.0	273,456,272.6
310001	Улсын төсвөөс санхүүжих	284,339,000.0	273,456,272.6
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,500,000.0	914,824.0
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,500,000.0	914,824.0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	40	0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	0
610001	Төсвийн байгууллага	1	0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	20	18
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	13	11
620003	Үйлчлэх ажилтан	6	6
620004	Гэрээт ажилтан	0	0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	20	18
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	12	12
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8	6

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	88,891,140.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	88,891,140.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	88,514,500.0
2104	Хангамж, бараа материалын зардал	2,293,500.0
210402	Тээвэр, шатахуун	2,293,500.0
2107	Томилолт, зочны зардал	3,312,500.0
210702	Дотоод албан томилолт	3,312,500.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	82,879,000.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	82,879,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,000.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,000.0
213	Урсгал шилжүүлэг	376,640.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	376,640.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	88,891,140.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	88,891,140.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	88,891,140.0
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Говьсүмбэр аймгийн “Мал эмнэлгийн газар”-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн тогтвортой байдалтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Дарханбат гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр, Дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Говьсүмбэр аймгийн “Мал эмнэлгийн газар”-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 01/16 дугаар албан бичгээр хуульд заасан хугацаанд ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Говьсүмбэр аймгийн “Мал эмнэлгийн газар” нь үйл ажиллагааны зорилтоо Төрөөс мал эмнэлгийн талаар хэрэгжүүлж буй бодлого, шийдвэрийг орон нутагт зөв зохион байгуулж хэрэгжүүлэх замаар мал, амьтны халдварт, гоц халдварт, шимэгчтэх өвчинтэй тэмцэж халдварт өвчингүй тайван газар нутгийг дотооддоо баталгаажуулан хадгалах, малын гаралтай түүхий эд, хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд шууд нөлөөлөх мал эмнэлгийн ажил үйлчилгээг чанарын өндөр түвшинд гүйцэтгэж зах зээлд нийлүүлэгдэх хүнсний аюулгүй байдлыг хангах, боловсруулах үйлдвэрт нийлүүлэгдэх түүхий эдийн чанарт ахиц дэвшил гаргах, малчин өрхийн санхүүгийн чадавхыг сайжруулахад бодитой үр нөлөө үзүүлэхэд оршино гэж тодорхойлсон.

Төрөөс мал эмнэлгийн үйлчилгээг шинэчлэх зорилго, чиглэлд нийцүүлэн дараах зорилтыг дэвшүүлж ажиллаж байна. Үүнд:

1. Био аюулгүйн хоёрдугаар зэрэглэлийг хангасан лаборатори бүхий мал эмнэлгийн иж бүрэн барилга, байгууламжийг стандартын шаардлагад нийцүүлэн шинээр барьж байгуулах
2. Мэргэжлийн чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх, мэргэшүүлэх, тогтвортой ажиллах орчин нөхцөлийг бий болгох
3. Мал эмнэлгийн ажил үйлчилгээнд шинэ дэвшилтэт технологи, инноваци, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг нэвтрүүлэх
4. Малыг болон нийтийн эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг оновчтой зөв зохион байгуулж, чанарын өндөр түвшинд гүйцэтгэх
5. Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчнөөр тайван статусыг хангах
6. Төрөөс мал эмнэлгийн талаар хэрэгжүүлж буй бодлого шийдвэрийг аймгийн хэмжээнд удирдан зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцох

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Говьсүмбэр аймгийн “Мал эмнэлгийн газар” нь дотоод аудитын нэгж бүтэцгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говьсүмбэр аймгийн “Мал эмнэлгийн газар”-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 971,944.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 14,579.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 10,205.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Говьсүмбэр аймгийн “Мал эмнэлгийн газар”-ын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 74,619.3 мянган төгрөгөөр буюу 17.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс урьдчилгаа, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгө, өр, төлбөр, эздийн өмч дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			-
Урьдчилгаа	1.7	-	-1.7
Урьдчилж гарсан зардал		7,200.0	7,200.0
Бараа материал	236,796.7	212,405.2	-24,391.5
Үндсэн хөрөнгө	179,364.0	205,971.2	26,607.2
Нийт хөрөнгө	416,162.4	425,576.4	9,414.0
Өр төлбөр	93.1	-	-93.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	416,069.3	425,576.4	9,507.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	416,162.4	425,576.4	9,414.0

Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл 7,200.0 мянган төгрөг болж нэмэгдсэн нь дээд шатны төсөв захирагчаас төсвийн хуваарьт өөрчлөлт оруулан мэдээлэл технологийн үйлчилгээний зардал 10,800.0 мянган төгрөгийг баталсан ба “Дата ланд” ХХК-тай байгуулсан гэрээгээр 2021 оны үйлчилгээний төлбөрт 3,600.0 мянга, 2022 оны төлбөрт 7,200.0 мянган төгрөгийг төлөхөөр үүрэг хүлээснээс шалтгаалан урьдчилж төлсөн зардлын авлага үүсжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 212,405.2 мянган төгрөг болж 24,391.5 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оноос үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалын хэмжээ 247,312.0 мянган төгрөгөөр буурсан, хадгалалтын хугацаа дууссан 1,595.2 мянган төгрөгийн вакциныг акталж устгасантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 179,364.0 мянган төгрөг байсан ба тайлант хугацаанд аймгийн Засаг даргын 2021 оны А/68 дугаар захирамжийг үндэслэн 67,200.0 мянган төгрөгийн газар эзэмших эрхийг биет бус хөрөнгийн дансанд, төсвийн хөрөнгөөр 4,249.0 мянган төгрөгийн хөрөнгийг машин тоног төхөөрөмжийн дансанд тус тус орлого авсан нь нөлөөлжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 416,069.3 мянган төгрөгөөс 425,576.4 мянган төгрөг болж 9,507.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь газар эзэмших эрх 67,200.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, өмнөх онд шатахууны зарцуулаагүй үлдэгдлийг төлбөрийн актаар буцаан төвлөрүүлсний улмаас өмнөх үеийн үр дүнг бууруулсан 1,474.9 мянга, тайлант үеийн үр дүн -56,218.0 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Говьсүмбэр аймгийн “Мал эмнэлгийн газар”-ын 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 427,472.6 мянган төгрөгөөр буюу 39.1 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 247,312.1 мянга, нэмэлт санхүүжилт дансны орлого 110,148.7 мянга, нийт 357,460.8 мянган төгрөгөөр буурч, улсын төсвийн санхүүжилт 36,766.4 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна. Нэмэлт санхүүжилтийн орлого өмнөх оноос буурсан нь Мал эмнэлэг, үржлийн газраас шүлхий, боом, галзуу, бруцёллез, мялзан, хонины цэцэг өвчний тарилга, үйлчилгээний хөлсөнд 193,656.6 мянган төгрөгийн санхүүжилт олгож байсан нь нөлөөлжээ.

Нийт зардал өмнөх оноос 251,127.1 мянган төгрөгөөр буюу 25.8 хувиар буурсан байна. Үүнд вакцинжуулалттай холбоотойгоор эм, бэлдмэлийн зардал өмнөх онд 516,073.7 мянга байсан бол тайлант онд 308,480.2 мянган төгрөг болж, 207,593.5 мянган төгрөгөөр буурсан нь нөлөөлжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 475,793.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 475,793.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 208,925.6 төгрөгөөр бууруулж 266,867.7 мянган төгрөгөөр баталсан бөгөөд тайлант хугацаанд нийт 4 удаа төсөвт өөрчлөлт оруулж жилийн эцсийн байдлаар 285,839.0 мянган төгрөгөөр санхүүжилтийг баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 70801, 70805 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 285,839.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 284,339.0 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр, 1,500.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 285,839.0 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч 274,371.1 мянган төгрөгийг зарцуулж, 11,467.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Үүнээс зардлын хэмнэлт нь 10,882.7 мянган төгрөг, орлогын төлөвлөгөө биелээгүйгээс 585.2 мянган төгрөгийн санхүүжилт дутуу авснаас шалтгаалжээ.

Хүснэгт 2. Гүйцэтгэлийн тайлангийн үзүүлэлт

(мянган төгрөгөөр)

Хөтөлбөрийн код нэр	Арга хэмжээний код, нэр	Төлөв	Гүйц	Зөрүү
	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	65,710.9	63,628.0	2,082.9
	82502-Монгол мал хөтөлбөр	6,660.1	6,660.1	-
70801-Мал аж ахуйг хөгжүүлэх	82504-Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх	1,680.0	1,680.0	-
	82507-Малын архаг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх	13,843.0	13,843.0	-
	82508-Малын өвчний лабораторийн онош	2,000.0	2,000.0	-
70805-ХАА газар тариалан бодлого	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	179,935.0	170,550.0	9,385.0
	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж	16,010.0	16,010.0	-
Нийт дүн		285,839.0	274,371.1	11,467.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар Ариун цэврийн төв лабораториос 7,218.6 мянга, Мал эмнэлгийн ерөнхий газраас 82,097.8 мянга, нийт 89,316.4 мянган төгрөгийн орлого орсон бөгөөд үүнээс 425.3 мянган төгрөгийн санхүүжилтийг буцаасан тул санхүүгийн тайланд 88,891.1 мянган төгрөгийн эх үүсвэр тайлагнажээ.

Үүнээс гүйцэтгэлээр бруцеллөз, шүлхий өвчний тандалт шинжилгээгээр 6,416.7 мянга, шүлхий өвчний тарилгын хөлс 82,097.8 мянган төгрөгийг зарцуулж, 376.6 мянган төгрөгийн үлдэгдлийг төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Аудитаар Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108, А/111 дүгээр тушаалаар батлагдсан ерөнхий чиглэлд тусгагдсан асуудлыг онцолсон.

Тус байгууллага нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг зөрчиж батлагдсан төсөвт 10 хувь хүртэлх хэмнэлт гаргаагүй, байрны түрээсийн зардлыг төсвийн жилийн дундуур шинээр хуваарьт тусган нэмэгдүүлсэн, төсвийн зарлагын эдийн засгийн ангилал зөрчин, эрх бүхий байгууллагын тушаал шийдвэргүйгээр үндсэн хөрөнгө худалдан авсан гэх мэт зөрчлүүд илэрсэн бөгөөд асуудлын бүртгэлд тусгаж, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага өгсөн.

Мөн дээд шатны төсвийн захирагчаас захирагчаас тэвчиж болох буюу мэдээлэл технологийн үйлчилгээний зардалд 10,800.0 мянган төгрөгийг хуваарилан 2022 оны төлбөрийг урьдчилан шилжүүлж, 7,200.0 мянган төгрөгийн авлага үүсгэсэн нь анхаарал татаж байна.

3.8 Аудитын гол асуудал

Төсвийн хяналтын нэгдсэн онлайн платформ //www.opengov.mn/-ны 2022 оны төлбөрийг урьдчилж шилжүүлэн 7,200.0 мянган төгрөгийн авлага үүсгэсэн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.8-д заасан мэдээллийн давхардал, ач холбогдол үр нөлөөг харгалзан Шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Говьсүмбэр аймгийн “Мал эмнэлгийн газар” нь 2021 онд нийт 628,093.0 мянган төгрөгийн 63 мэдээллийг байршуулахаас 129,436.6 мянган төгрөгийн 12 мэдээллийг байршуулаагүй зөрчилтэй байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн худалдан авах ажиллагааны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Говьсүмбэр аймгийн “Мал эмнэлгийн газар” нь өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 5 сарын 25-ны 01/93, 11 сарын 16-ны 01/210 дугаартай албан бичгээр ирүүлсэн бөгөөд зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

3.11 дараагийн аудитаар анхаарах асуудал илрээгүй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 134,362.3 мянган төгрөгийн 9 алдаа зөрчил илэрснээс, 2,591.6 мянган төгрөгийн 5 алдааг залруулж, 130,021.7 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 1,749.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай 2,591.6 мянган төгрөгийн дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Хагас жилийн санхүүгийн тайланд 89.9 мянган төгрөгийн өр төлбөрийг үүсгэсэн байсан бөгөөд жилийн эцэст өр төлбөрийг барагдуулсан тул залруулгаар бүртгэсэн.
2. Завсрын аудитын нярав үндсэн хөрөнгийн тайланг данс тус бүрээр бэлтгээгүй байсан бөгөөд жилийн эцэст дансны ангилал бүрээр тайлан бэлтгэж ирүүлсэн тул залруулгаар бүртгэсэн.
3. Акталж устгасан 517.2 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаар тайлагнасан.
4. Санхүүгийн үр дүнгийн тайланд 1,833.8 мянган төгрөгийн цалингийн зардлыг НДШ-ийн зардлаар тайлагнасныг залруулсан.
5. ХХОАТ-ын тайланд 1 ажилтны 150.7 мянган төгрөгийн цалин хөлсийг тайлагнаагүй байсныг залруулсан.

4.2 Албан шаардлага

1. Завсрын аудитаар өгсөн авлага, өр төлбөргүй ажиллах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй. “Дата ланд” ХХК-тай гэрээ байгуулж төсвийн хяналтын цахим программын 2022 оны үйлчилгээний төлбөрийг урьдчилан шилжүүлж, 7,200.0 мянган төгрөгийн авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10 дахь заалтыг тус тус зөрчсөн ба санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т заасны дагуу албан шаардлага өгөв.

2. Орлогын төлөвлөгөөг батлахдаа бодит тооцоо судалгаанд үндэслээгүйгээс 585.2 мянган төгрөгөөр дутуу бүрдүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн

41.2.1 заалтыг зөрчсөн ба санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.5-т заасны дагуу албан шаардлага өгөв.

3. Шилэн дансны цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний 112,310.8 мянган төгрөгийн 10 гүйлгээ, цалингийн зардлаас дээш 5 сая төгрөгийн 17,125.7 мянган төгрөгийн 2 гүйлгээ, батлагдсан төсөвт орсон өөрчлөлтийг мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, 6.4.1, 6.4.4, 6.4.5 дах заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т заасны дагуу албан шаардлага өгөв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал зөрчиж цалингийн зардлаас ажил олгогчоос төлөх шимтгэл төлсөн, бусдаар гүйцэтгүүлсэн бараа ажил үйлчилгээний зардлаас тоног төхөөрөмж худалдан авсан.

1.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг мөрдөж ажиллах, үндсэн хөрөнгө худалдан авах зайлшгүй шаардлагатай тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Говьсүмбэр аймгийн Мал эмнэлгийн газар	9	134,362.3	5	2,591.6	0	0	3	130,021.7	1	1,749.0